| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 6.00 | 6.00 |
| 650010 | Гэрээт ажилтан | 4.00 | 4.00 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 10.00 | 10.00 |

2.5 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|------------|--------------------------------------------------|-----------|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | |
|-------------|-------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------|
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 32,095,114.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 32,095,114.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 32,095,114.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 20,945,714.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 20,945,714.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,190,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,190,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,959,400.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,959,400.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 32,095,114.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 32,095,114.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 19,110,800.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 12,984,314.00 |
| IV | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | 2,000,000.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | |

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Булган сумын Сумын Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөгөө зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, Засаг даргын бүрэн эрхийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, ИТХ, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах, хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах, хууль тогтоомжийн биелэлтийг хангах, иргэдэд хуульд заасан үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж ажилласан байна.

Булган сум нь “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх төрийн бодлогыг сумынхаа онцлогт тохируулан боловсруулж, үр дүнтэй хэрэгжүүлэх өндөр чадвартай, зөв зохион байгуулалттай, хариуцлагатай удирдлагын тогтолцоог бүрдүүлж, ард иргэдийнхээ амьдрах орчин сайжруулах, аж амьдралыг дээшлүүлэх” эрхэм зорилго дэвшүүлэн ажиллажээ.

Дээрх зорилгын хүрээнд: Ажлын хариуцлагыг дээшлүүлж, иргэдэд хүнд сурталгүй цаг хугацаанд үйлчилгээ үзүүлэх, орон нутгийн бизнесийн таатай орчныг бүрдүүлж, эдийн засгийн өсөлтийг хангаж улмаар сумын төсөв санхүүгийн хариуцлага, хяналтыг сайжруулж, ил тод үр ашигтай байдлыг эрхэмлэн, орон нутгийн хөгжлийг дэмжсэнээр сумын эдийн засгийн өсөлтийг иргэн бүрд хүргэж, ядуурлыг буруулах зорилт дэвшүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль,

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч 2024 онд шалгалтад хамрагдаагүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Булган сумын Засаг даргын тамгын газрын даргын 2023 оны 09 дугаар сарын 10-ны өдрийн А/08 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажилласан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар баталсан “Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 148.9 сая төгрөгөөр буюу 5.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---------------------|--------------------|--------------------|--------------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 306,348.7 | 237,097.4 | (69,251.4) |
| Авлага | 196,305.7 | 172,665.0 | (23,640.7) |
| Урьдчилгаа | - | 0.0 | 0.0 |
| Бараа материал | 120,286.8 | 98,682.5 | (21,604.3) |
| Үндсэн хөрөнгө | 1,864,748.5 | 1,830,348.1 | (34,400.5) |
| Нийт хөрөнгө | 2,487,689.8 | 2,338,793.0 | (148,896.8) |

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
|----------------------------------------------|--------------------|--------------------|--------------------|
| Өр төлбөр | - | 103,794.0 | 103,794.0 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 2,487,689.8 | 2,234,999.0 | (252,690.8) |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 2,487,689.8 | 2,338,793.0 | (148,896.8) |

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 237,097.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 69,251.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | /мянган төгрөгөөр/ |
|------------------------------|------------------|------------------|---------------------------|
| | | | Өсөлт (+), Бууралт (-) |
| Кассад байгаа бэлэн мөнгө | - | - | - |
| Банканд байгаа бэлэн мөнгө | 306,348.7 | 237,097.4 | (69,251.3) |
| Төгрөг | 306,348.7 | 237,097.4 | (69,251.3) |
| Төрийн сангийн харилцах | 299,410.2 | 236,751.3 | (62,658.9) |
| Арилжааны банк дахь харилцах | 6,938.5 | 346.1 | (6,592.4) |
| Дүн | 306,348.7 | 237,097.4 | (69,251.3) |

Эх сурвалж: Аудитын судалгаа.

Оны эцэст Төсвийн ерөнхий орлогын дансанд 78.1 сая төгрөгийн, ОНХС-д 45.7 сая төгрөгийн, Сум хөгжүүлэх сангийн дансанд 112.9 сая төгрөгийн, Эмийн эргэлтийн санд 346.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Аудитын илрүүлэлт: Мөнгөн хөрөнгө данстай холбоотой зөрчил гараагүй.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 172.6 сая төгрөг болж, өмнөх оноос 23.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | /мянган төгрөгөөр/ |
|-------------------------------|------------------|------------------|---------------------------|
| | | | Өсөлт (+), Бууралт (-) |
| Ажиллагчтай холбогдсон авлага | - | - | - |
| Төлбөртэй үйлчилгээний авлага | - | - | - |
| Зээлийн хүүгийн авлага | - | - | - |
| Байгууллагаас авах авлага | 9,397.2 | 2,928.7 | -6,468.5 |
| Хувь хүмүүсээс авах авлага | 5,200.0 | - | -5,200.0 |
| Зээлийн авлага | 181,708.5 | 169,736.3 | -11,972.2 |
| Хувь хүмүүст олгосон зээл | 181,708.5 | 169,736.3 | -11,972.2 |
| Дүн | 196,305.7 | 172,665.0 | -23,640.7 |

сурвалж: Аудитын судалгаа

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Байгууллагаас авах авлага 6.4 сая төгрөгөөр /Эргэлтийн эмийн сангийн авлага 2.9 сая төгрөгөөр/, хүмүүсээс авах авлага 5.2 сая төгрөгөөр, Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлага 11.9 сая төгрөгөөр буурсан байна.

- Аудитын илрүүлэлт: Авлага данстай холбоотой зөрчил гараагүй.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилж гарсан зардал дансанд өөрчлөлт ороогүй байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 98.6 сая төгрөг болж, өмнөх оноос 21.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

| Үзүүлэлт | /мянган төгрөгөөр/ | | |
|------------------------------|--------------------|-----------------|---------------------------|
| | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
| Түүхий эд материал | 24,049.5 | 24,310.6 | 261.1 |
| Тусгай зориулалттай материал | 236.2 | 236.2 | 0 |
| Эм боох материал | 23,579.7 | 23,840.8 | 261.1 |
| Бэлэн бүтээгдэхүүн | 233.6 | 233.6 | - |
| Хангамжийн материал | 96,237.3 | 74,371.9 | -21,865.4 |
| Бичиг хэргийн материал | 2,215.6 | 1,965.0 | 250.6 |
| Аж ахуйн материал | 15,571.9 | 12,275.9 | 329.6 |
| Сэлбэг хэрэгсэл | - | - | - |
| Түлш, шатах тослох материал | 5,059.0 | 7,143.0 | 2,084.0 |
| Хүнсний материал | - | - | - |
| Бусад хангамжийн материал | 73,390.8 | 52,988.0 | -20,402.8 |
| Мал амьтад | - | - | - |
| Дүн | 120,286.8 | 98,682.5 | -21,604.3 |

Эх сурвалж: Аудитын судалгаа

ЗДТГ 72.1 сая төгрөгийн, ИТХ 2.7 сая төгрөгийн, Эмийн эргэлтийн сан 23.8 сая төгрөгийн нийтдээ 98.7 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

- Аудитын илрүүлэлт: Бараа материал данстай холбоотой зөрчил гараагүй.

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө:

Бусад эргэлтийн хөрөнгө байхгүй байна.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 1,830.3 сая төгрөг болж, өмнөх оноос 1,901.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

| Үзүүлэлт | /мянган төгрөгөөр/ | | |
|--------------------------------|--------------------|--------------------|---------------------------|
| | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
| Биет хөрөнгө | 3,712,041.4 | 1,811,419.4 | -1,497,443.5 |
| Барилга, байгууламж, орон сууц | 839,302.4 | 637,419.8 | 198,882.6 |
| Авто-тээврийн хэрэгсэл | 223,929.9 | 169,452.8 | 54,477.1 |

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
|----------------------------------|--------------------|--------------------|---------------------|
| Машин тоног төхөөрөмж(компьютер) | 404,212.3 | 77,237.4 | 326,974.9 |
| Тавилга, аж ахуйн эд хогшил | 34,354.0 | 11,611.9 | -22,742.1 |
| Зам, гүүрийн байгууламж | 1,807,063.9 | 721,891.2 | -1,085,172.7 |
| Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | - | - | - |
| Бусад үндсэн хөрөнгө | 403,178.9 | 193,806.3 | -209,372.6 |
| Дуусаагүй барилга, байгууламж | - | - | 0 |
| Ном | - | - | 0 |
| Биет бус хөрөнгө | 19,973.1 | 18,928.6 | -1,044.5 |
| Программ хангамж | 3,306.6 | 2,262.1 | -1,044.5 |
| Бусад биет бус хөрөнгө | 16,666.5 | 16,666.5 | 0 |
| Дүн | 3,732,014.5 | 1,830,348.0 | -1,901,666.5 |

Эх сурвалж: Аудитын судалгаа

Үндсэн хөрөнгийн данс оны эхэнд 3,732.0 . сая төгрөгийн үлдэгдэлтэй ба 11.5 сая төгрөгийн хөрөнгийн худалдан авч, 224.4 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, 270.3 , сая төгрөгийн элэгдэл байгуулж оны эцэст 1,830.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

- Аудитын илрүүлэлт: Үндсэн хөрөнгө данстай холбоотой зөрчил гараагүй.

3.5.7 Өр төлбөр

Өр төлбөр данс оны эцэст 103.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарч оны эхнээс 103.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/ мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|----------------------------------|----------------|------------------|---------------------------|
| Өглөг | - | 103,794.0 | 103,794.0 |
| Ажилчидтай холбогдсон өглөг | - | - | - |
| Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | - | - |
| Бусад өглөг | - | 103,794.0 | 103,794.0 |
| Байгууллагад төлөх өглөг | - | 57,425.9 | 57,425.9 |
| Хувь хүмүүст төлөх өглөг | - | 45,721.3 | 45,721.3 |
| НДШ-ийн өглөг | - | 646.8 | 646.8 |
| Дүн | - | 103,794.0 | 103,794.0 |

Эх сурвалж: Аудитын судалгаа

ОНХС 45.7 сая төгрөгийн, Эмийн эргэлтийн сан 646.8 мянган төгрөгийн, ЗДТГазар 55.7 сая төгрөгийн, ИТХурал 1.7 сая төгрөгийн өглөгтэй гарсан байна.

- Аудитын илрүүлэлт: Өглөг данстай холбоотой зөрчил гараагүй.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 252.7 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

/ сая төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|--------------------------------------------------------------------------|----------------|-----------------|---------------------------|
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 850,766.8 | 850,766.8 | 0 |

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
|----------------------------------|--------------------|--------------------|--------------------|
| Хуримтлагдсан үр дүн | 760,622.9 | 507,932.1 | (252,690.8) |
| Өмнөх үеийн үр дүн | 638,927.5 | 760,622.9 | (121,695.4) |
| Тайлант үеийн үр дүн | 121,695.4 | -252,690.8 | 374,386.2 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 876,300.1 | 876,300.1 | 0 |
| Дүн | 2,487,689.8 | 2,234,999.0 | -252,690.8 |

Эх сурвалж: Аудитын судалгаа

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Булган сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,237.4 сая төгрөгөөр, төсвийн зарлагыг 2,485.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн тодотголоор 247.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 2,485.3 сая төгрөгөөр баталсан байна. Нийт зардлын 1,751.4 сая төгрөгийг сумын орон нутгийн төсвийн орлогын санхүүжилтээр, 418.2 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас, 200.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос 115.7 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Булган сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2024 онд гүйцэтгэлээр нийтдээ 2,101.7 сая төгрөгийн тусламж санхүүжилтийн орлого бүрдүүлсэн байна. Үүнд: сумын орон нутгийн төсвөөс 1,623.8 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сангаас 401.0 сая төгрөгийн санхүүжилт авч, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 75.9 сая төгрөгийн орлого, туслах үйл ажиллагааны орлогоос 1.0 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Үндсэн үйл ажиллагааны орлогын 75.9 сая төгрөг нь **ХХС-гийн** орлого байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,168.8 сая төгрөг буюу 87.3 хувьтай байгаа нь төвлөрүүлсэн болон дутуу авсан санхүүжилт, мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй холбоотой байна.

Сумын орон нутгийн төсвийн орлогын талаар:

Аймгийн ИТХ-ын 2023 оны “Орон нутгийн төсөв батлах тухай” 73 дугаар тогтоолоор Булган сумын 2023 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 952.8 сая төгрөгөөр баталж, аймгийн ИТХ-ын 2024 оны “2023 оны төсөвт тодотгол хийх тухай” 76 дугаар тодотголоор 952.8 сая төгрөгөөр хэвээр нь баталсан байна.

Сумын ИТХ-ын 2024 оны А/06 дугаар тогтоолоор 2024 орлогын төлөвлөгөөг 358.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 1,310.8 сая төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлогод 1,235.1 сая төгрөгийн орлого оруулж, орлогын төлөвлөгөөг 75.7 сая төгрөгөөр буюу 5.8 хувиар тасарсан байна.

Хүснэгт №2 Орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

| <u>Үзүүлэлт</u> | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | <u>/сая төгрөг/</u> | |
|------------------------|------------|-----------|---------------------------------------|----------------------------------|
| | | | <u>Өсөлт/+/</u> <u>бууралт /-/</u> | <u>Дүнд эзлэх</u> <u>хувь</u> |
| I.Татварын орлого | 1,303.6 | 1,206.4 | -97.2 | 92.5 |
| II.Татварын бус орлого | 7.2 | 28.7 | 21.5 | 396.0 |

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | | |
|-----------------|----------------|----------------|-------------|-------------|
| Нийт дүн | 1,310.8 | 1,235.1 | 75.7 | 94.2 |
|-----------------|----------------|----------------|-------------|-------------|

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Орон нутгийн татварын орлогод 1,303.6 сая төгрөг төлөвлөгдөж, гүйцэтгэлээр 1,206.4 сая төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөө 97.2 сая төгрөгөөр буюу 7.5 хувиар тасарсан. Татварын бус орлогод 7.2 сая төгрөг төлөвлөж гүйцэтгэлээр 28.7 сая төгрөг оруулан 21.5 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Орлогын нэр төрлөөр авч үзэхэд үйл ажиллагааны орлогын албан татварыг 63.2 сая төгрөгөөр, хөрөнгийн орлогыг 16.2 сая төгрөгөөр, хөрөнгө борлуулсан орлогыг 0.5 сая төгрөгөөр, бууны албан татвар 1.3 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамжийг 1.3 сая төгрөгөөр, газрын төлбөрийг 00.4 сая төгрөгөөр, хүү торгуулийн орлогыг 8.1 сая төгрөгөөр, давж, төсөвт газрын өөрийн орлогоос 13.4 сая төгрөгийн орлого оруулсан нь төлөвлөгөөний биелэлтэд голлон нөлөөлсөн байна.

Цалин хөлс түүнтэй адилтгах орлого 159.5 сая төгрөгөөр, малын тоо, толгойн албан татвар 5.4 сая төгрөгөөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 7.7 сая төгрөгөөр, үл хөдлөх хөрөнгийн татвар 2.3 сая төгрөгөөр, хог хаягдлын үйлчилгээний хураамж 2.1 сая төгрөгөөр, ойгоос мод түлээ мод бэлтгэж ашигласны төлбөр 3.3 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын татварын орлогоос ХХОАТ-ын буцаан олголтод 23.9 сая төгрөг олгосон байна.

Орон нутгийн ерөнхий орлогын 910 тоот дансанд оны эхэнд 73.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба 1,643.1 сая төгрөгийн татварын орлого төвлөрүүлж, оны эцэст 78.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт №3 Төсвийн байгууллагуудын 2023 оны төсвийн зарлагын гүйцэтгэл:

/сая төгрөг/

| Д/д | Байгууллагын нэр | Батлагдсан төсөв | Гүйцэтгэл | Хэтрэлт, хэмнэлт |
|-----|----------------------------------|------------------|----------------|------------------|
| 1 | ИТХУрал | 196.1 | 171.5 | -24.6 |
| 2 | ЗДТГазар | 1,127.8 | 1,067.4 | -60.4 |
| 3 | Ерөнхий боловсролын 1-р сургууль | 176.8 | 174.5 | -2.3 |
| 4 | Ерөнхий боловсролын 2-р сургууль | 51.6 | 47.9 | -3.7 |
| 5 | Ерөнхий боловсролын 3-р сургууль | 45.9 | 40.4 | -5.5 |
| 6 | Хүүхдийн цэцэрлэг | 43.2 | 43.2 | - |
| 7 | Хүүхдийн цэцэрлэг-2 | 13.2 | 13.0 | -0.2 |
| 8 | Соёлын төв | 13.2 | 12.2 | -1.0 |
| 9 | Эрүүл мэндийн төв | 47.7 | 33.7 | -14.0 |
| 10 | ОНХСан | 569.8 | 503.9 | -65.9 |
| 11 | СХСан | 200.0 | 61.1 | -138.9 |
| | Нийт дүн | 2,485.3 | 2,168.8 | -316.5 |

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Сумын ЗДТГ, ИТХ-ын төсвийн гүйцэтгэл төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй гарсан төлөвлөлттэй холбоотой, ОНХС-гийн төсвийн гүйцэтгэлд 5 төсөл хөтөлбөрийн ажил дутуу хийгдсэн нь нөлөөлсөн байна.

Нэмэлт санхүүжилт

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2024 онд 32.1 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авсан байна. Үүнд: дээд шатны төсвийн захирагчаас нийт 19.1 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогоос 13.0 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт хүлээн авч тээвэр шатахууны зардалд 20.9 сая, дотоод албан томилолт 1.2 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 10.0 сая төгрөгийг зарцуулжээ. Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлого ороогүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2024 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Еркебулан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 60 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 2,662.2 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 39.9 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх шатны материаллаг байдлыг Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,146.3 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 32.2 сая төгрөгөөр аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангаж ажилласан ба алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгасан.

Шилэн дансанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын нийтдээ 1,546.3 сая төгрөгийн 26 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 1,734.2 сая төгрөгийн 22 мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 100.1 сая төгрөгийн 5 мөнгөн гүйлгээг бүрэн мэдээлсэн байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100 хувьтай байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар алдаа, зөрчил илрээгүй тул нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

- *Аудитын илрүүлэлт: Шилэн данстай холбоотой зөрчил гараагүй байна.*

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа зөрчилтэй суудал гараагүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар Булган сумын Хоршоо хөгжүүлэх сангийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг барагдуулах 95.1 сая төгрөгийн албан шаардлагын хэрэгжилт 26.1 хувьтай байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах зүйл байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1. Сумын ТТЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн талаар

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн, 4 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 1 байгууллага, 2 сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан.

Булган сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль, Сайхан багийн ерөнхий боловсролын сургууль, Сөнхөл багийн ерөнхий боловсролын сургууль, Сумын хүүхдийн цэцэрлэг, Ёлт багийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төвийн орон нутгийн төсвөөс олгосон тогтмол зардлын санхүүжилтийг нэгтгэлд хамруулсан байна.

Сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд “өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн. Сумын ИТХ, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж үзсэн.

Засаг даргын тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Орон нутгийн хөгжлийн сан, Хоршоо хөгжүүлэх сангийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 56.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч үүнээс 9.9 сая төгрөгийн алдааг залруулж, 2.8 сая төгрөгийн төлбөрийн 1 акт тогтоож, 44.0 сая төгрөгийн 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн.

Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль, Сөнхөл багийн ерөнхий боловсролын сургууль, Сайхан багийн ерөнхий боловсролын сургууль, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд “өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн. Сумын хүүхдийн цэцэрлэг, Ёлт багийн цэцэрлэг, Соёлын төвийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж үзсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа бусад байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийтдээ 1,559.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч үүнээс 805.9 сая төгрөгийн алдааг залруулж, 8.1 сая төгрөгийн төлбөрийн 4 акт тогтоож, 730.8 сая төгрөгийн 3 албан шаардлага, 14.3 сая төгрөгийн 8 зөвлөмж өгсөн байна.

Хүснэгт 4: Төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлангаас илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл /сая төгрөгөөр/

| Д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|--------------------------------------|-------------------------------------|----------------------|-------------|-----------|------------|---------------|------------|-----------------|-------------|----------|-----|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | ЗДТГазар | 2 | 2.8 | | | 1 | 2.8 | | | 1 | |
| 2 | ИТХурал | 1 | 9.9 | 1 | 9.9 | | | | | | |
| 3 | ОНХС | 1 | 44.0 | | | | | 1 | 44.0 | | |
| 4 | ХХС | | | | | | | | | | |
| Орон нутгийн байгууллагын дүн | | 4 | 56.7 | 1 | 9.9 | 1 | 2.8 | 1 | 44.0 | 1 | |
| 1 | ЕБ-ын 1-р сургууль | 4 | 11.1 | 1 | 3.6 | 1 | 3.0 | | | 2 | 4.5 |
| 2 | ЕБ-ын Сөнхөл багийн сургууль | 1 | | | | | | | | 1 | |
| 3 | ЕБ-ын Сайхан багийн сургууль | 6 | 72.3 | 3 | 70.9 | | | | | 3 | 1.4 |
| 4 | Хүүхдийн цэцэрлэг | 10 | 596.2 | 7 | 236.9 | | | 2 | 350.9 | 1 | 8.4 |
| 5 | Ёлт цэцэрлэг | 1 | 4.1 | | | 1 | 4.1 | | | | |
| 6 | Соёлын төв | 9 | 29.1 | 8 | 28.6 | 1 | 0.5 | | | | |
| 7 | Эрүүл мэндийн төв | 4 | 846.3 | 2 | 465.9 | 1 | 0.5 | 1 | 379.9 | 1 | |

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | | | | | | | | |
|------------------------|----|---------|----|-------|---|------|---|-------|---|------|
| Бусад байгууллагын дүн | 36 | 1,559.1 | 21 | 805.9 | 4 | 8.1 | 3 | 730.8 | 8 | 14.3 |
| Нийт дүн | 40 | 1.615.8 | 22 | 815.8 | 5 | 10.9 | 4 | 774.8 | 9 | 14.3 |

5.2. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар залруулга хийгдээгүй, зөрчил илрээгүй.

Аудитын дүнгээр Сумын Засаг дарга, Санхүүгийн албад дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

1. Сумын төсөвт байгууллагуудын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчилд өгсөн 10.9 сая төгрөгийн төлбөрийн 5 актыг хугацаанд нь барагдуулах, 774.8 сая төгрөгийн 4 албан шаардлага, 14.3 мянган төгрөгийн 9 зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тайлагнаж ажиллах;

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|-------------------|------------|-----|-----------------------------------|-----|--------------------------|-----|------------|-----|--------------|-----|---------|-----|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---------------------------------------------------------------------|-------------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|--------------------------------------|---------------------|-------------------------------------------------|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| ТТЗ-ийн харьяа байгууллагуудад өгсөн аудитын шийдвэрийн хэрэгжилтэд | 1 | | | | | | | 1 | | | | |

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | | | | | | | | | |
|---------------------------------|----------|--|--|--|--|----------|--|--|--|--|--|
| хяналт тавьж, үр дүнг тайлагнах | | | | | | | | | | | |
| Дүн | 1 | | | | | 1 | | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|----------------------------------------------------------|-------------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | | |